



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН  
СТАТИСТИКИЙН МЭДЭЭ  
2024 оны 4 дүгээр сар**

*/УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР/*

Улаанбаатар хот,  
2024 оны 05 сарын 06

**АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....</b>	<b>4</b>
1.1. Ачаа тээвэр.....	5
1.2. Зорчигч тээвэр.....	6
<b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....</b>	<b>7</b>
2.1. Ачаа тээвэр.....	7
2.1.1. Экспортын ачаа, боомтоор.....	8
2.1.2. Импортын ачаа, боомтоор.....	9
2.1.3. Ачааны нэр төрөл.....	10
2.1.4. Ачаа эргэлт, боомтоор.....	10
2.2. Зорчигч тээвэр.....	11
2.3. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
<b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>	<b>13</b>
3.1. Ачаа тээвэр.....	13
3.2. Зорчигч тээвэр.....	15
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>	<b>17</b>
4.1. Ачаа тээвэр.....	17
4.2. Зорчигч тээвэр.....	18
4.2.2. Олон улсын зорчигч тээвэр.....	19
4.2.3. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
4.3. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	4
Хүснэгт 2. Автотээврийн ачаа.....	7
Хүснэгт 3. Автотээврийн ачааны экспорт, боомтоор.....	8
Хүснэгт 4. Автотээврийн ачааны импорт, боомтоор.....	9
Хүснэгт 5. Автотээврээр тээсэн ачааны нэр төрөл.....	10
Хүснэгт 6. Ачаа эргэлт, боомтоор.....	10
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч тээвэр.....	11
Хүснэгт 8. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
Хүснэгт 9. Төмөр замын ачаа тээвэр.....	13
Хүснэгт 10. Төмөр замын зорчигч тээвэр.....	15
Хүснэгт 11. Агаарын тээврийн ачаа.....	17
Хүснэгт 12. Агаарын тээврийн зорчигч.....	18
Хүснэгт 13. Олон улсын зорчигч тээвэр.....	19
Хүснэгт 14. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
Хүснэгт 15. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	5
Зураг 2. Нийт экспорт.....	5
Зураг 3. Нийт импорт.....	5
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	6

Зураг 5. Олон улсад зорчигч.....	6
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	6
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	7
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	7
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн боомтоор.....	8
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....	9
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар .....	10
Зураг 12. Автотээврээр зорчсон зорчигч.....	11
Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	12
Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн.....	13
Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	14
Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 4 дүгээр сарын хоногийн мэдээ.....	14
Зураг 19. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	15
Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр.....	16
Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор.....	16
Зураг 22. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	17
Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	17
Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	17
Зураг 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	18
Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	18
Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	19
Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	20
Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	20
Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	21
Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	21

Боловсруулсан: Зам, тээврийн хөгжлийн яамны  
Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа,  
стандарт, статистикийн хэлтэс

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН  
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>1</sup>

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт бууралтын %
				4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	5189.25	19,651.8	7,012.3	24,788.7	26.1%
		Төмөр зам	мян.тн	3145.9	12,538.9	3,466.1	14,141.4	12.8%
		Агаар	мян.тн	0.67	2.87	0.75	2.95	2.6%
		<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>8,335.8</b>	<b>32,193.6</b>	<b>10,479.1</b>	<b>38,933.0</b>	<b>20.9%</b>
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	428.9	1,548.4	428.0	1,682.3	8.6%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	1,022.5	3,901.8	863.5	3,558.7	-8.8%
		Автотээвэр	мян.тн	4,996.4	19,177.9	6,779.4	24,119.3	25.8%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>6,018.9</b>	<b>23,079.7</b>	<b>7,642.9</b>	<b>27,678.1</b>	<b>19.9%</b>
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	266.8	1,064.2	310.5	1,340.8	26.0%
		Автотээвэр	мян.тн	192.9	473.9	232.9	669.4	41.2%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>459.7</b>	<b>1,538.1</b>	<b>543.4</b>	<b>2,010.2</b>	<b>30.7%</b>
5	Дотоод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,427.7	6,024.5	1,864.0	7,559.5	25.5%
		Агаар	мян.тн	0.67	2.87	0.75	2.95	2.6%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>1,428.4</b>	<b>6,027.4</b>	<b>1,864.8</b>	<b>7,562.5</b>	<b>25.5%</b>
6	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,047.6	46,088.3	13,915.7	47,796.9	3.7%
		Төмөр зам	мян.хүн	181.2	654.1	151.3	570.8	-12.7%
		Агаар	мян.хүн	103.3	421.6	138.7	550.7	30.6%
		<b>Нийт зорчигч</b>	<b>мян.хүн</b>	<b>13,332.1</b>	<b>47,164.0</b>	<b>14,205.7</b>	<b>48,918.4</b>	<b>3.7%</b>
7	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	73.3	180.4	41.9	141.0	-21.8%
		Төмөр зам	мян.хүн	1.3	4.7	2.6	9.8	107.9%
		Агаар	мян.хүн	72.9	302.2	105.2	420.1	39.0%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>147.5</b>	<b>487.3</b>	<b>149.8</b>	<b>570.9</b>	<b>17.1%</b>
8	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	102.0	447.7	124.2	540.6	20.8%
		Төмөр зам	мян.хүн	179.9	649.4	148.7	561.0	-13.6%
		Агаар	мян.хүн	30.4	119.4	33.5	130.6	9.4%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>312.2</b>	<b>1,216.5</b>	<b>306.3</b>	<b>1,232.2</b>	<b>1.3%</b>
9	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,872.3	45,460.2	13,749.6	47,115.3	3.6%



<sup>1</sup> Зам, тээврийн салбарын 2024 оны 04 дүгээр сарын статистикийн мэдээг урьдчилсан гүйцэтгэлээр “Салбарын нэгдсэн платформ”-оос нэгтгэн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гаргав.

### 1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2024 оны 04 дүгээр сард 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 25.7%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр буюу эхний 4 сард 38.9 сая тонн ачаа тээсэн нь өмнөх онтой харьцуулахад 20.9%-аар өссөн байна.

- 2024 оны 04 дүгээр сард автотээврээр 7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 35.1%-аар өссөн байна. Үүнээс экспортод 6.8 сая тонн (+35.7%), импортоор 232.9 мянган тонн (+20.8%) ачаа тээвэрлэсэн байна. Өссөн дүнгээр нийт 24.8 сая тонн ачаа тээсэн нь 26.1%-аар, экспортын ачаа 24.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 25.8%-аар, импортын ачаа 669.4 мянган тонн болж 41.2%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2024 оны 04 дүгээр сард нийт 3.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.2 %-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.9 сая тонн (+30.6%), импортын ачаа 310.5 мянган тонн (+16.4%), экспортын ачаа 863.5 мянган тонн (-15.5%), дамжин өнгөрсөн ачаа 428 мянган тонн (-0.2%) тээвэрлэсэн байна. Өссөн дүнгээр нийт 14.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 12.8 %-аар, дотоодын ачаа 7.6 сая тонн болж 25.5%-аар, импортын ачаа 1.3 сая тонн болж 26%-аар, дамжин өнгөрсөн ачаа 1.7 сая тонн болж 8.6%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 3.6 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 8.8%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2024 оны 04 дүгээр сард 754.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 12.4%-аар өссөн. Үүнээс ачаа 735.5 тонн (+25.1%), шуудан 19.1 (-77.1%) тонн тээвэрлэсэн. Өссөн дүнгээр 2946 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6%-аар өссөн байна. Үүнээс ачаа 2868 тонн (+21%), шуудан 78 тонн (-84.5%) тээвэрлэсэн байна.


Зураг 1. Нийт ачаа тээвэр, мян.тонн



04 дүгээр сард экспортоор 7.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 27%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын хэмжээ 27.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 19.9%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 3.6 сая тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.8%-аар буурсан бол автотээврээр 24.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 25.8%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 87.1%-ийг, төмөр зам 12.9%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2024 оны 04 дүгээр сард нийт 543.4 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 18.2%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 2 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 30.7%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 1.3 сая тонн ачаа импортолсон нь 26%-аар, автотээврээр 669.4 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 41.2%-аар тус тус өссөн байна. Төмөр замаар 67%-ийг, автотээврээр 33%-ийг тээсэн байна. /Зураг 3/

Зураг 3. Нийт импорт




## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2024 оны 04 дүгээр сард 14.2 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6%-аар өссөн бол оны эхнээс өссөн дүнгээр 48.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Авто тээврээр 2024 оны 04 дүгээр сард 13.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6.7%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 41.9 зорчигч (-42.8%), орон нутагт 124154 зорчигч (+21.8%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.7 сая зорчигч (+6.8%) тус тус зорчсон байна. Өссөн дүнгээр нийт 47.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 47.1 сая зорчигч (+3.6%), орон нутагт 540.6 мянган зорчигч (+20.8%), олон улсад 141 мянган зорчигч (-21.8%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- 2024 оны 4 дүгээр сард нийт 151.3 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 16.5%-аар буурсан. Үүнээс олон улсад 2.6 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол орон нутагт 148.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 17.4%-аар буурсан байна. Өссөн дүнгээр нийт 570.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.7%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 9.8 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол харин орон нутагт 561 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.6%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 4 дүгээр сард нийт 138.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 34.3%-аар өссөн. Үүнээс олон улсад 105.2 мянган зорчигч (+44.3%), орон нутагт 33.5 мянган зорчигч (+10.2%) зорчсон байна. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 550.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 30.6%-аар өссөн бол үүнээс олон улсад 420.1 мянган зорчигч зорчсон нь 39%-аар, орон нутагт 130.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 9.4%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсад зорчигч

- Автотээвэр
- Төмөр зам
- Агаарын тээвэр

2024 оны эхний 4 сард олон улсад нийт 570.9 мянган зорчигч (+17.1%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 420.1 мянган зорчигч (+39%), автотээврээр 141 мянган зорчигч (-21.8%), төмөр замаар 9.8 мянган зорчигч (+107.9%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 73%, автотээвэр 25%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2024 оны эхний 4 сард орон нутагт нийт 1.2 сая зорчигч (+1.3%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 540.6 мянган зорчигч (+20.8%), төмөр замаар 561 мянган зорчигч (-13.6%), агаарын тээврээр 130.6 мянган зорчигч (+9.4%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**

**2.1. АЧАА ТЭЭВЭР**


2024 оны эхний 4 сард авто замаар нийт 24.8 сая тонн ачаа тээвэрлэснээс 24.1 сая тонн ачаа экспортолсон байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Хүснэгт 2
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	Өсөлт, бууралтын %
<b>Нийт ачаа тээвэр</b>	<b>тонн</b>	<b>5,189,247.0</b>	<b>19,651,825.0</b>	<b>7,012,287.0</b>	<b>24,788,687.4</b>	<b>26.1%</b>
Ачааны импорт	тонн	192,878.0	473,947.0	232,924.0	669,356.4	41.2%
Ачааны экспорт	тонн	4,996,369.0	19,177,878.0	6,779,363.0	24,119,331.0	25.8%
Ачаа эргэлт	тн.км	745,449,868.0	3,080,461,903.0	959,268,120.0	3,619,086,280.4	17.5%

2024 оны 04 дүгээр сард автотээвэрээр 7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 35.1%-аар өссөн байна. Үүнээс экспортод 6.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 35.7%-аар, импортоор 232.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 20.8%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 04 дүгээр сард 959.3 тэрбум тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 28.7%-аар өссөн байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.


**Зураг 7. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар**



Эхний 4 сар буюу өссөн дүнгээр нийт 24.8 сая тонн ачаа тээсэн нь 26.1%-аар, экспортын ачаа 24.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 25.8%-аар, импортын ачаа 669.4 мянган тонн болж 41.2%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 2959.2 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 26.6%-аар өссөн байна.

2024 оны эхний 4 сарын байдлаар нийт ачаа тээврийн 24.1 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 669.4 мянган тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 53.3%-ийг бүрдүүлж байна. Харин импортын ачааны 79.1%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

**Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь**




## Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 4 дүгээр сар

### 2.1.1. ЭКСПОРТЫН АЧАА, БООМТООР

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Хүснэгт 3 Өсөлт, бууралтын %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	<b>Нийт ачаа тээвэр</b>	тонн	<b>5,189,247.0</b>	<b>19,651,825.0</b>	7,012,287.0	24,788,687.4	26.1%
2	<b>Ачааны экспорт-боомтуудаар</b>	тонн	4,996,369.0	19,177,878.0	6,779,363.0	24,119,331.0	25.8%
3	ОХУ-руу	тонн	22,184.0	53,416.0	2,068.0	14,341.1	-73.2%
4	Алтанбулаг	тонн	8,330.0	18,418.0	2,068.0	14,341.1	-22.1%
5	Боршоо	тонн	0.0	0.0	0.0	0.0	0.0%
6	Цагаан нуур	тонн	13,854.0	34,998.0	0.0	0.0	-100.0%
7	БНХАУ-руу	тонн	4,974,185.0	19,124,462.0	6,777,295.0	24,104,989.9	26.0%
8	Бичигт	тонн	192,691.0	533,724.0	20,286.0	422,237.0	-20.9%
9	Баянхошуу	тонн	49,470.0	522,791.0	42,457.0	169,106.6	-67.7%
10	Бургастай	тонн	2,079.0	133,140.0	14,356.0	154,102.0	15.7%
11	Булган	тонн	273,360.0	974,365.0	297,691.0	925,331.0	-5.0%
12	Гашуунсухайт	тонн	2,576,118.0	10,162,250.0	3,300,875.0	12,866,142.6	26.6%
13	Замын-Үүд	тонн	18,245.0	490,413.0	72,204.0	291,736.0	-40.5%
14	Ханги	тонн	425,298.0	1,523,575.0	674,031.0	2,440,542.7	60.2%
15	Хавирга	тонн	14,923.0	32,557.0	0.0	9,453.0	-71.0%
16	Шивээ хүрэн	тонн	1,421,842.0	4,751,488.0	2,355,395.0	6,826,339.0	43.7%
17	Сүмбэр	тонн	159.0	159.0	0.0	0.0	-100.0%

2024 оны 04 дүгээр сард автотээвэрээр экспортод 6.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 35.7%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын ачаа 24.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 26.1%-аар өссөн байна. Үүнд Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдсэн нь нийт экспортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

**Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор**



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2024 оны 04 сард 2.1 мянган тонн ачаа, харин өссөн дүнгээр 14.3 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оноос 73.2%-аар буурсан байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтоор 04 сард 6.8 сая тонн ачаа гарсан. Харин өссөн дүнгээр 24.1 сая тонн ачаа гарсан нь 26%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачаа Гашуунсухайт боомтоор 12.9 сая тонн (+26.6%) буюу нийт экспортын 53.3%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 6.8 сая тонн (+43.7%), Ханги боомтоор 2.4 сая тонн (+60.2%), Булган боомтоор 925.3 мянган тонн (-5%), Бичигт боомтоор 422.2 мянган тонн (-20.9%), Замын-Үүд боомтоор 291.7 мянган тонн (-40.5%), Бургастай боомтоор 154.1 мянган тонн (+15.7%), Баянхошуу боомтоор 169.1 мянган тонн (-67.7%), Хавирга боомтоор 9.5 мянган тонн (-71%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/



2.1.2 ИМПОРТЫН АЧАА, БООМТООР

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	5,189,247.0	19,651,825.0	7,012,287.0	24,788,687.4	26.1%
2	Ачааны импорт –боомтуудаар	тонн	192,878.0	473,947.0	232,924.0	669,356.4	41.2%
3	ОХУ-аас	тонн	31,381.0	92,457.0	32,400.0	131,304.9	42.0%
4	Алтанбулаг	тонн	16,283.0	49,379.0	17,837.0	60,099.9	21.7%
5	Боршоо	тонн	1,747.0	5,479.0	3,323.0	17,757.0	224.1%
6	Цагаан нуур	тонн	13,351.0	37,599.0	11,240.0	53,448.0	42.2%
7	БНХАУ-аас	тонн	161,497.0	381,490.0	200,524.0	538,051.5	41.0%
8	Бичигт	тонн	0.0	0.0	654.0	2,247.0	-
9	Баянхошуу	тонн	360.0	1,529.0	38.0	38.0	-97.5%
10	Бургастай	тонн	0.0	0.0	84.0	84.0	-
11	Булган	тонн	0.0	0.0	0.0	0.0	0.0%
12	Гашуунсүхайд	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
13	Замын-Үүд	тонн	160,772.0	379,223.0	195,876.0	529,336.5	39.6%
14	Ханги	тонн	226.0	289.0	0.0	0.0	-100.0%
15	Хавирга	тонн	139.0	449.0	3,872.0	6,346.0	1313.4%
16	Шивээ хүрэн	тонн	0.0	0.0	0.0	0.0	0.0%

Автотээвэрээр 2024 оны 04 дүгээр сард импортоор 232.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 20.8%-аар өссөн байна. Үүнээс 32.4 мянган тонныг ОХУ-аас, 200.5 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.


2024 оны эхнээс өссөн дүнгээр импортын ачаа 669.4 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 41.2%-аар өссөн байна. Үүнд Боршоо, Хавирга боомтоор орж ирсэн ачааны хэмжээ нэмэгдсэн нь нийт импортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

Эхний 4 сард ОХУ-аас 131.3 мянган тонн, БНХАУ-аас 538.1 мянган тонн ачаа оруулж ирсэн байна. Импортын ачааны 80%-ийг БНХАУ-аас, 20%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 79%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.**

БНХАУ-аас Замын-Үүд боомтоор 529.3 мянган тонн ачаа (+39.6%), Бичигт боомтоор 2.2 мянган тонн ачаа, Хавирга боомтоор 6.3 тонн ачаа оруулсан байна.

ОХУ-аас Алтанбулаг боомтоор 60.1 мянган тонн (+21.7%), Цагааннуур боомтоор 53.4 мянган тонн (+42.2%), Боршоо боомтоор 17.8 мянган тонн (+224.1%) ачаа тус тус орж иржээ. /Зураг 10/

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор



2.1.3. АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
Нүүрс	тонн	4,911,483.6	17,824,061.6	6,608,318.3	23,367,879.2	31.1%
Газрын тос	тонн	48,381.9	194,071.2	42,457.4	169,106.6	-12.9%
Зэсийн баяжмал	тонн	59,560.0	221,360.0	80,951.3	296,577.0	34.0%
Төмрийн хүдэр	тонн	2,238.0	133,298.7	26,648.2	185,918.5	39.5%
Жонш	тонн	0.0	0.0	8,433.5	28,788.0	-
Бусад	тонн	0.0	830,381.0	12,554.3	84,390.8	-89.8%

Авто замын боомтоор гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 04 дүгээр сард 6.6 сая тонн (+34.5%), зэсийн баяжмал 80.9 мянган тонн (+35.9%), газрын тос 42.5 мянган тонн (-12.2%), төмрийн хүдэр 26.6 мянган тонн (\*10), жонш 8.4 мянган тонн, бусад ачаа 12.6 мянган тонн ачаа гаргасан байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нүүрс 23.4 сая тонн (+31.1%), зэсийн баяжмал 296.6 мянган тонн (+34%), төмрийн хүдэр 185.9 мянган тонн (+39.5%), газрын тос 169.1 мянган тонн (-12.9%), жонш 28.8 мянган тонн, бусад 84.4 мянган тонн ачаа тус тус экспортолсон байна. /Зураг 11/

Зураг 11 .Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



2.1.4. АЧАА ЭРГЭЛТ, БООМТООР

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа эргэлт	тн.км	745,449,868.0	3,080,461,903.0	959,268,120.0	3,619,086,280.4	17.5%
2	Алтанбулаг	тн.км	566,099.0	1,559,331.0	457,815.0	1,712,141.9	9.8%
3	Бичигт	тн.км	15,415,280.0	42,697,920.0	1,675,200.0	33,958,720.0	-20.5%
4	Баянхошуу	тн.км	31,891,200.0	335,564,800.0	27,196,800.0	108,252,544.0	-67.7%
5	Бургастай	тн.км	166,320.0	10,651,200.0	1,155,200.0	12,334,880.0	15.8%
6	Гашуунсухайт	тн.км	592,507,140.0	2,337,317,500.0	759,201,250.0	2,959,212,798.0	26.6%
7	Замын-Үүд	тн.км	1,253,119.0	6,087,452.0	1,876,560.0	5,747,507.5	-5.6%
8	Цагаан нуур	тн.км	2,720,500.0	7,259,700.0	1,124,000.0	5,344,800.0	-26.4%
9	Ханги	тн.км	8,510,480.0	30,477,280.0	13,480,620.0	48,810,854.0	60.2%
10	Шивээ хүрэн	тн.км	92,419,730.0	308,846,720.0	153,100,675.0	443,712,035.0	43.7%

2024 оны эхнээс өссөн дүнгээр автотээврийн ачаа эргэлт нийт 3619.1 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 17.5%-аар өссөн байна. Үүнээс ачаа эргэлт хамгийн их байгаа боомт болох Гашуунсухайтаар 2959.2 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 82%-ийг дангаар бүрдүүлж байна. Харин хамгийн их өсөлттэй байгаа боомт нь Ханги буюу тус боомтоор 48 сая тонн км ачаа эргэлт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 60.2%-аар өссөн байна. /Хүснэгт 6/

## 2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Автотээвэрээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр 47.8 сая зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 3.7%-аар өссөн байна.

*Хүснэгт 7*

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
<b>Нийт зорчигч тээвэр</b>	<i>хүн</i>	<b>13,047,589.0</b>	<b>46,088,290.0</b>	<b>13,915,722.0</b>	<b>47,796,941.0</b>	<b>3.7%</b>
Олон улсад зорчигчид	<i>хүн</i>	73,305.0	180,385.0	41,949.0	141,028.0	-21.8%
Хот хоорондын зорчигч	<i>хүн</i>	101,952.0	447,668.0	124,154.0	540,576.0	20.8%
Хот доторх нийтийн тээвэрээр зорчигч	<i>хүн</i>	12,872,332.0	45,460,237.0	13,749,619.0	47,115,337.0	3.6%



Автотээвэрээр 2024 оны 04 дүгээр сард 13.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6.7%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 41.9 зорчигч (-42.8%), орон нутагт 124154 зорчигч (+21.8%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.7 сая зорчигч (+6.8%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 47.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээвэрээр 47.1 сая зорчигч (+3.6%), орон нутагт 540.6 мянган зорчигч (+20.8%), олон улсад 141 мянган зорчигч (-21.8%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.6%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.1%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 12/

## 2.3. АВТО ЗАМЫН БООМТООР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

*Хүснэгт 8*

Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
	<b>67,253</b>	<b>229,304</b>	<b>73,198.0</b>	<b>281,778.0</b>	<b>22.9%</b>
<b>Орсон тээврийн хэрэгсэл</b>	<b>8,560</b>	<b>22,537</b>	<b>11,222.0</b>	<b>52,719.0</b>	<b>133.9%</b>
БНХАУ-аас	6,624	16,864	9,209.0	45,071.0	167.3%
Бичигт	0	0	0.0	0.0	0.0%
Баянхошуу	100	173	3.0	3.0	-98.3%
Булган	142	275	0.0	0.0	-100.0%
Бургастай	0	2	3.0	3.0	50.0%
Гашуунсухайт	181	965	647.0	1,186.0	22.9%
Шивээхүрэн	8	75	277.0	21,278.0	28270.7%
Замын-Үүд	6,171	15,339	8,169.0	22,187.0	44.6%
Ханги	15	16	17.0	157.0	881.3%
Хавирга	7	19	93.0	257.0	1252.6%
ОХУ-аас	1,936	5,673	2,013.0	7,648.0	34.8%
Алтанбулаг	1,125	3,368	1,093.0	3,766.0	11.8%
Боршоо	95	265	157.0	774.0	192.1%
Цагааннуур	716	2,040	763.0	3,108.0	52.4%
<b>Гарсан тээврийн хэрэгсэл</b>	<b>58,693</b>	<b>206,767</b>	<b>61,976.0</b>	<b>229,059.0</b>	<b>10.8%</b>
БНХАУ-руу	44,192	156,089	59,560.0	220,412.0	41.2%
Бичигт	0	0	323.0	5,755.0	-
Баянхошуу	1,341	5,338	1,194.0	4,815.0	-9.8%
Булган	3,746	11,007	4,207.0	12,810.0	16.4%
Бургастай	50	2,337	440.0	4,924.0	110.7%
Гашуунсухайт	19,518	76,646	27,423.0	103,087.0	34.5%
Шивээхүрэн	13,019	37,382	17,484.0	56,017.0	49.9%
Замын-Үүд	462	2,076	1,101.0	4,566.0	119.9%
Ханги	5,926	20,972	7,281.0	28,220.0	34.6%
Хавирга	127	328	107.0	218.0	-33.5%
Сүмбэр	3	3	0.0	0.0	-100.0%
ОХУ-руу	14,501	50,678	2,416.0	8,647.0	-82.9%
Алтанбулаг	13,409	47,818	839.0	3,236.0	-93.2%
Боршоо	98	242	128.0	742.0	206.6%
Цагааннуур	994	2,618	1,449.0	4,669.0	78.3%

Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Монгол Улсын авто замын боомтоор 2024 оны 04 дүгээр сард нийт 73198 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс 11222 тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны мөн үеэс 31.1%-аар, 61976 тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны мөн үеэс 5.6%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 8/

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 281778 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 22.9%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаа тээврийн хэрэгсэл 52719 буюу 2 дахин, гарсан тээврийн хэрэгсэл 229059 болж өмнөх оны мөн үеэс 10.8%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 13/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

3.1. АЧАА ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2024 оны эхний 4 сард нийт 14.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх онтой харьцуулахад 12.8%-аар өслөө.


Хүснэгт 9

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
<b>Ачаа тээвэрлэлт</b>	<i>мян.тн</i>	3,145.9	12,538.9	3,466.1	14,141.4	12.8%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	2,621.1	10,746.2	2,562.8	2.0%	3.3%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	140.8	417.8	219.2	73.2%	82.2%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	119.6	275.9	292.9	239.4%	311.7%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	264.4	1,099.0	318.1	19.0%	18.6%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	0.0	0.0	73.0	-	-
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	1,427.7	6,024.5	1,864.0	7,559.5	25.5%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	902.9	4,231.8	960.7	4,375.7	3.4%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	140.8	417.8	219.2	723.8	73.2%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	119.6	275.9	292.9	936.4	239.4%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	264.4	1,099.0	73.0	1,063.0	-3.3%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	0.0	0.0	318.1	460.6	-
Импорт ачаа	<i>мян.тн</i>	266.8	1,064.2	310.5	1,340.8	26.0%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	1,022.5	3,901.8	863.5	3,558.7	-8.8%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	428.9	1,548.4	428.0	1,682.3	8.6%


Төмөр замын тээврээр 2024 оны 04 дүгээр сард нийт 3.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.2 %-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.9 сая тонн болж өмнөх оны 04 дүгээр сараас 30.6%-аар, импортын ачаа 310.5 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.4%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 863.5 мянган тонн болж өмнөх оноос 15.5%-аар, дамжин өнгөрсөн ачаа 428 мянган тонн болж 0.2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 9/

Өссөн дүнгээр нийт 14.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 12.8 %-аар, дотоодын ачаа 7.6 сая тонн болж 25.5%-аар, импортын ачаа 1.3 сая тонн болж 26%-аар, дамжин өнгөрсөн ачаа 1.7 сая тонн болж 8.6%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 3.6 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 8.8%-аар буурсан байна. /Зураг 14/

Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн




Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь




Эхний 4 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 10.9 сая тонн буюу 77.5%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.3 сая тонн буюу 9.3%-ийн ачааг “Монголиантранс Ложистик” ХХК, 936.4 мянган тонн буюу 6.6%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 723.8 мянган тонн буюу 5.1%-ийн ачааг “Монголын төмөр зам” ТӨХК, 215.5 мянган тонн ачаа буюу нийт ачааны 1.5%-ийг “Монголиантранс Лайн” ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 15/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 7.6 сая тонн буюу 53.5%-ийг дотоодын ачаа, 3.6 сая тонн буюу 25.2%-ийг экспортын ачаа, 1.7 сая тонн буюу 11.9%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1.3 сая тонн буюу 9.5%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 16/

Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл




Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Дотоодод тээвэрлэсэн 7.6 сая тонн ачааны 4.4 сая тонн ачаа буюу 57.9%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.1 сая тонн ачаа буюу 14.1%-ийг “Монголиантранс Ложистик” ХХК, 936.4 мянган тонн буюу 12.4%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 723.8 мянган тонн ачаа буюу 9.6%-ийг “Монголын төмөр зам” ТӨХК, 460.6 мянган тонн буюу 6.1%-ийг “Монголиантранс Лайн” ХХК тус тус эзэлж байна. /Зураг 17/


Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 4 дүгээр сарын хоногийн мэдээ, 2024.04.01-2024.04.31



“УБТЗ” ХНН-ийн ачаа тээврийн 04 дүгээр сарын хоногийн мэдээг Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. /Зураг 18/

2024 оны эхний улирал буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.04.30-ны өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг19/

Зураг 19 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



Байгууллагуудын хоногт тээвэрлэх хүчин чадал буюу ачаа тээврийн хоногийн дундажийг эхний 4 сарын байдлаар тооцоход “УБТЗ” ХНН хоногт дунджаар 88.1 мянган тонн, “МТЛожистик” ХХК нь 10.8 мянган тонн, “ТТЗ” ХХК нь 7.7 мянган тонн, “МТЗ” ТӨХК нь 6 мянган тонн, “МТЛайн” ХХК нь хоногт дунджаар 1.8 мянган тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна.


### 3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

**Төмөр замаар 2024 оны I улиралд 7.1 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 2.1 дахин өссөн байна.**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
<b>Зорчигч тээвэрлэлт</b>	<i>мян.хүн</i>	181.2	654.1	151.3	570.8	-12.7%
Олон улс	<i>мян.хүн</i>	1.3	4.7	2.6	9.8	107.9%
Орон нутаг	<i>мян.хүн</i>	179.9	649.4	148.7	561.0	-13.6%
Зорчигч эргэлт	<i>сая хүн.км</i>	68.6	228.1	65.8	238.6	4.6%

2024 оны 4 дүгээр сард нийт 151.3 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 16.5%-аар буурсан. Үүнээс олон улсад 2.6 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол орон нутагт 148.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 17.4%-аар буурсан байна.

Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр




Оны эхнээс өссөн дүнгээр нийт 570.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.7%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 9.8 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол харин орон нутагт 561 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.6%-аар буурсан байна.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаа бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна.

Нийт төмөр замаар зорчигчдын 98% нь орон нутагт зорчсон бол 2% нь олон улсад зорчсон байна. /Зураг 20/

Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор




2024 оны эхний 4 сар буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.04.30-ны өдөр хүртэл “УБТЗ” ХНН нь нийт 570.8 мянган зорчигч төмөр замаар тээвэрлэсэн байна. Эхний 4 сарын байдлаарх хоногийн дунджийг тооцоход төмөр замаар хоногт дунджаар 4627 зорчигч төмөр замаар зорчоод байна. /Зураг 21/



**БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР**  
**4.1 АЧАА ТЭЭВЭР**

Хүснэгт 11

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	<b>Нийт ачаа, шуудан тээвэр</b>	тн	671.4	2,872.6	754.5	2,946	2.6%
2	олон улсад	тн	668.8	2,866.4	752.9	2,939	2.5%
3	орон нутагт	тн	2.6	6.2	1.6	7	15.0%
4	<b>Нийт ачаа</b>	тн	588.1	2,370.0	735.5	2,868	21.0%
5	олон улсад	тн	585.9	2,365.4	733.8	2,861	21.0%
6	орон нутагт	тн	2.2	4.6	1.6	7	55.4%
7	<b>Нийт шуудан</b>	тн	83.3	502.7	19.1	78	-84.5%
8	олон улсад	тн	82.9	501.1	19.1	78	-84.5%
9	орон нутагт	тн	0.41	1.61	0	0	-99.4%




Агаарын тээвэрээр 2024 оны 04 дүгээр сард 754.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 12.4%-аар өссөн. Үүнээс ачаа 735.5 тонн болж өмнөх оны 04 дүгээр сараас 25.1%-аар өссөн бол шуудан 19.1 тонн болж өмнөх оноос 77.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр 2946 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6%-аар өссөн байна. Үүнээс ачаа 2868 тонн тээвэрлэсэн нь 21%-аар өссөн бол шуудан 78 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 84.5%-аар буурсан байна. /Зураг 22/


Оны эхнээс өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 2939 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 7 тонн болж өмнөх оны мөн үеэс 15%-аар өссөн байна. /Зураг 23/

Агаарын тээвэрээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.2%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.4%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.6%-ийг шуудан эзэлж байна.

**Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан**



**Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар**




## 4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт 550.7 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 30.6%-аар өслөө.

Хүснэгт 12

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
<b>Нийт зорчигч тээвэр</b>	<i>хүн</i>	103,275	421,636	138,685	550,663	30.6%
Олон улсад	<i>хүн</i>	72,923	302,230	105,232	420,064	39.0%
Орон нутагт	<i>хүн</i>	30,352	119,406	33,453	130,599	9.4%

Зураг 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо




2024 оны 04 дүгээр сард агаарын тээврээр нийт 138.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 34.3%-аар өссөн. Үүнээс олон улсад 105.2 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 44.3%-аар, орон нутагт 33.5 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 10.2%-аар тус тус өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 550.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 30.6%-аар өссөн бол үүнээс олон улсад 420.1 мянган зорчигч зорчсон нь 39%-аар, орон нутагт 130.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 9.4%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 12/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь харагдаж байна./Зураг 26/

Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 13


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралт %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	<b>Нийт зорчигч тээвэр</b>	хүн	<b>103,275</b>	<b>421,636</b>	<b>138,685</b>	<b>550,663</b>	29.5%
2	<b>Олон улсад</b>	хүн	<b>72,923</b>	<b>302,230</b>	<b>105,232</b>	<b>420,064</b>	37.4%
3	чиглэл Сөүл	хүн	31,784	132,349	33,537	133,729	1.0%
4	Бээжин	хүн	6,918	16,736	20,213	70,999	324.2%
5	Истанбул	хүн	10,148	37,252	11,261	40,215	8.0%
6	Токио	хүн	7,119	25,516	9,720	33,702	32.1%
7	ХонКонг	хүн	3,488	10,424	6,259	25,469	144.3%
8	Франкфурт	хүн	2,994	11,512	4,846	18,467	60.4%
9	Фукуок	хүн	0	3,894	254	18,071	364.1%
10	Бусад чиглэлд	хүн	1,237	16,840	1,784	14,266	-15.3%
11	Хөх хот	хүн	845	2,598	4,674	12,232	370.8%
12	Бангкок	хүн	95	10,771		10,927	1.4%
13	Бусан	хүн	3,213	9,491	2,367	8,878	-6.5%
14	Пукет	хүн	0	6,320		7,900	25.0%
15	Хайлаар/Хөлөнбуйр	хүн		0	2,772	6,462	-
16	Алмата	хүн	1,248	4,425	1,685	5,137	16.1%
17	Эрхүү	хүн	659	2,588	1,259	4,591	77.4%
18	Манжуур	хүн	732	839	1,176	3,664	336.7%
19	Гуанжоу	хүн	1,648	1,823	2,634	2,798	53.5%
20	Ханой	хүн	95	5,565		1,888	-66.1%
21	Чанша/Фукуок	хүн	0	279	552	1,116	300.0%
22	Улаан-Үд	хүн	560	2,260		497	-78.0%
23	Захиалгат	хүн	140	748		238	-68.2%

2024 оны эхнээс өссөн дүнгээр олон улсад нийт 420.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 37.4%-аар өссөн. Сөүл чиглэлд мянган зорчигч 133.7 (+1%), Бээжин хот руу 70.9 мянган зорчигч (+324.2%), Истанбул хот руу 40.2 мянган зорчигч (+8%), Токио чиглэлд 33.7 мянган зорчигч (+32.1%), ХонгКонг-руу 25.5 мянган зорчигч (+144.3%), Фукуок чиглэлд 18.1 мянган зорчигч (+364.1%) тус тус тээвэрлэсэн байна. Үүнээс Манжуур, Бээжин, Фукуок, Хөх хот чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Зураг 27/

Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр олон улсад 212.9 мянган зорчигч зорчсон бол “Korean Air”-ийн нислэгээр 39.6 мянга, “Airchina”-ийн нислэгээр 39.7 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 31.3 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 24.5 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 24.8 мянга, “Изинис Эйрвейз” ХХК-ийн нислэгээр 12 мянга, Жэжү айр нислэгээр 16.3 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 12.3 мянга, Ираеро нислэгээр 5 мянган зорчигч, Красавиа нислэгээр 580, захиалгат нислэгээр 363 зорчигч зорчсон байна. /Зураг 28/

#### 4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 14

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
1	Нийт зорчигч тээвэр	хүн	103,275	421,636	138,685	550,663	30.6%
2	Орон нутагт зорчигч тээвэр	хүн	30,352	119,406	33,453	130,599	9.4%
3	чиглэл Ховд	хүн	732	2,599	1,109	3,833	47.5%
4	Улаангом	хүн	190	641	272	858	33.9%
5	Алтай	хүн	0	36	748	2,515	6886.1%
6	Оюутолгой	хүн	28,540	112,681	29,514	115,154	2.2%
7	Оюутолгой/Даланзадгад	хүн	0	0	22	432	-
8	Мөрөн	хүн	0	99	273	1,027	937.4%
9	Өлгий	хүн	382	1,647	688	2,713	64.7%
10	Улиастай	хүн	396	1,282	432	1,744	36.0%
11	Даланзадгад	хүн	0	0	255	1,025	-
12	Мөрөн/Улаангом	хүн	0	0	140	1,049	-
13	Бусад		0	0	0	193	-


Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2024 оны 04 дүгээр сард орон нутагт нийт 33.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 10.2%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 130.6 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.4%-аар өссөн бол Оюутолгой чиглэлд нийт 115.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь 2.2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн бүх чиглэл тэр дундаа Алтай болон Мөрөн чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2024 оны эхний 4 сард агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 61.6% буюу 80.4 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 21.2% буюу 27.7 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 17.3% буюу 22.6 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутаг “МИАТ” ХХК-ийн зорчигч 24%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 2.4%-аар тус тус нэмэгдсэн бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 15%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 30/

### 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

Хүснэгт 15

Үзүүлэлт	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	4 дүгээр сар	Өссөн дүн	4 дүгээр сар	Өссөн дүн	
<b>Нийт нислэгийн тоо</b>	4,257	14,785	6,037	25,025	69.3%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	3,039	10,053	4,709	19,481	93.8%
Хөөрөлт, буулт	1,218	4,732	1,328	5,544	17.2%
Олон улсын хөөрөлт, буулт	557	2,344	758	3,190	36.1%
Орон нутгийн хөөрөлт, буулт	661	2,388	570	2,354	-1.4%

2024 оны 04 дүгээр сард нийт нислэгийн тоо 6037 болж өмнөх оны мөн үеэс 41.8%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 4709 болж өмнөх оны мөн үеэс 55%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 758 болж 36.1%-аар өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 570 болж 13.8%-аар буурсан байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нислэгийн тоо 25025 болж өмнөх оны мөн үеэс 69.3%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 19481 болж өмнөх оны мөн үеэс 93.8%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 3190 болж 36.1%-аар өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 2354 болж өмнөх оны мөн үеэс 1.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 31/

Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

